Цагдаагийн байгууллагын
100 жилийн ойд зориулав

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

/Албан хэрэгцээнд/

Улаанбаатар хот
2021 он

Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн ахмад С.Энхбаатар
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Нансал
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Э.Батгэрэл
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Амаржаргал
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Уянга
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Д.Гэрэлцэцэг
Мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Хулангоо
Дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Намсрай

Хянасан: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж
Дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Э.Халиунбаяр

Формат: А4/210*297/

Хэвлэлийн хуудас: 28.5хх
Хэвлэсэн тоо: 200 ширхэг

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ГАРЧИГ

НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ 5

ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 11

ГУРАВ. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 16

ДӨРӨВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 64

ТАВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 171

5.1 Хүнийг алах гэмт хэргийн нөхцөл байдал 171
5.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал 174
5.3 Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал 177
5.4 Хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал 180
5.5 Хувийн өмчийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал 183
5.6 Халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал 186
5.7 Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал 189
5.8 Дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал 192
5.9 Залилах гэмт хэргийн нөхцөл байдал 194
5.10 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн нөхцөл байдал 197
5.11 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал 200
5.12 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн нөхцөл байдал 203
5.13 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 206
5.14 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэргийн нөхцөл байдал 209

ЗУРГАА. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ 212
6.1 Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 212
6.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 215
6.3 Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 218
6.4 Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 221
6.5 Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 224

ДОЛОО. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ 227
7.1 Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 227
7.2 Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 230
7.3 Гадаадын иргэнээс үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 233

НАЙМ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ 235

ӨМНӨТГӨЛ

Цагдан сэргийлэх байгууллага анх үүссэн цагаас эхлэн гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийг хөтлөн, судалгаа, дүн шинжилгээ хийж эрх бүхий байгууллагыг мэдээ, мэдээллээр ханган, хууль сахиулах бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах, мэдээлэлд суурилсан цагдаагийн үйл ажиллагааг хөгжүүлсээр ирсэн билээ.

Мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ, судалгаа хийх нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын үндэс юм.

Цагдаагийн байгууллага нь 2006 оноос хойш “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” товхимлыг жил тутамд бэлтгэн 15 дахь удаагийн дугаараа Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан толилуулж байна.

Энэ удаагийн товхимолд дэлхий нийтийг цочирдуулсан коронавиурсийн халдварт өвчний улмаас үүссэн хөл хорио, нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс хамаарсан гэмт хэрэг, зөрчлийн статистик өгөгдлийг системийн динамик загварчлал, симуляц, корреляц зэрэг математикийн шинжлэх ухааны арга, аргачлал болон орчин үеийн аналитик програмуудын тусламжтай судалж, дүгнэлт, зөвлөмж боловсруулснаараа онцлог юм.

Товхимол нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулах, гэмт явдалд иж бүрэн дүн шинжилгээ судалгаа хийх, шат шатны сургалтын гарын авлага болгон ашиглах онол, практикийн ач холбогдолтой юм.

Товхимолд тусгагдсан статистик судалгаа түүнд үндэслэсэн зөвлөмж нь төрийн хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг судалгаа, шинжилгээнд үндэслэн явуулахад тань тустай байх болно гэдэгт итгэлтэй байна.

Бид үйл ажиллагаандаа олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001 стандартыг нэвтрүүлж, судалгаа шинжилгээний бүтээлүүддээ зохиогчийн эрхийн гэрчилгээ авч, статистик мэдээлэл бэлтгэхэд техник, технологийн ололт амжилтыг ашиглан “Мэдээллийн ухаалаг тогтолцоо” бүрдүүлэн, их өгөгдлийн дэд бүтцийг үүсгэх, түүнд дүн шинжилгээ /аналитик/ хийх мэргэшсэн албан хаагчдыг бэлтгэхийг зорин ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн талаар бодитой мэдээллийг цаг алдалгүй бүрдүүлж буй мэдээлэл судалгааны мэргэжилтэн болон цагдаагийн байгууллагын бүх шатны ажилтан, алба хаагч нарт Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас баримталж буй бодлого, үйл ажиллагааны чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байгаад талархал илэрхийлье.

Таныг хүндэтгэсэн,

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ,
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ж.БУЯНБАТ

НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхэд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан.

Энэхүү бүрэн эрхийг Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн", Арван зургадугаар зүйлийн 2 хэсэгт "...эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт... "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна..." гэж тус тус хуульчлан баталгаажуулсан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4-т "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн" гэж тусган гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн нэг хэсэг байна гэж үзсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг үр нөлөөтэй зохион байгуулах нь тухайн орны нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн индексэд шууд нөлөөлдөг болохыг дэлхийн өндөр хөгжилтэй ялангуяа Норвеги, Швед, Дани, Швейцар зэрэг улс орны туршлагаас харж болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал нь урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх шат дараалсан цогц арга хэмжээний нийлбэр бөгөөд зорилго, арга хэлбэр, ач холбогдлоороо эрс ялгаатай өөр өөр цогц үйл ажиллагаа юм. Тиймээс 2017 онд Улсын Их Хурлаас Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсан бөгөөд үг хуулиар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүх нийтийн үйлс гэж тодорхойлон төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн эрх үүргийг нарийвчлан заасан.

Энэ хүрээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд сар, улирал, хагас, бүтэн жилээр үнэлэлт дүгнэлт хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж шийдвэр гаргуулах, холбогдох төрийн захиргааны болон төрийн тусгай чиг үүргийн байгууллага, нутгийн захиргаа, иргэний нийгмийн байгууллагын үйлдааг холбоог сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дээр дурдсан гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллээр гэмт хэрэг 2020 онд өмнөх оноос гэмт хэрэг 26.8 хувиар буурч, бүртгэгдсэн зөрчил 4.6 хувиар өссөн үзүүлэлт гарсан бөгөөд үүнийг Улаанбаатар хот болон орон нутаг гэсэн хоёр хэсэгт хуваан дүн шинжилгээг хийлээ.

Улаанбаатар хотын нөхцөл байдал:

Улаанбаатар хотын хэмжээнд 2020 онд цагдаагийн байгууллагад ирсэн гомдол, мэдээллийн тоо өмнөх оноос 0.5 хувь, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 4.2 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 8.9 хувиар буурсан.

Дээрх хугацаанд бүртгэгдсэн нийт 23064 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 63.4 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байх бөгөөд цагдаагийн байгууллагын статистик мэдээллээр 2013 оноос хойш энэхүү үзүүлэлт 60.0 хувиас буураагүй байна.

Манай улсад өмнө нь бүртгэгдэж байсан гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлдэг тодорхой төрлийн гэмт хэрэг бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед буурсан.

Тухайлбал, нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй гарснаас хулгайлах 43.1, мал хулгайлах 42.5, дээрэмдэх 53.5, хүнийг алах 2.5, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 10.4, хүчиндэх 16.6, залилах гэмт хэрэг 8.9 хувиар тус тус буурсан байна.

Хэдийгээр дээрх төрлийн гэмт хэргүүд буурсан боловч нийт гэмт хэргийн 80.0 орчим хувь буюу 10 хэрэг тутмын 4 нь Өмчлөх эрхийн эсрэг, 2 нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь энэ чиглэлээр холбогдох байгууллага, аж ахуй нэгж, иргэд уруу чиглэсэн урьдчилан сэргийлэх ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Харин эсрэгээрээ Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 27.2, Хүний хувийн болон улс төрийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 66.7, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.6 дахин тус тус өсжээ. Энэ нь цар тахлын үеийн хөл хориотой холбоотойгоор иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаа хязгаарлагдаж, ажилгүйдэл, иргэдийн орлого буурсантай холбоотойгоор дээрх төрлийн гэмт хэрэг өссөн хамааралтай байна.

Түүнчлэн бүртгэгдсэн гэмт хэргийн 83.5 хувь нь хөнгөн, 16.5 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.5 хувиар, хүнд гэмт хэрэг 40.1 хувиар тус тус буурсан нь мөн цар тахлын хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой байна.

Улаанбаатар хотын дүүргүүдэд 2020 онд 10 000 хүн ам тутамд дунджаар 170 гэмт хэрэг ногдож бүй бөгөөд Сүхбаатар дүүрэг 330, Чингэлтэй дүүрэг 245 гэмт хэрэг ногдож байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй юм. Үүнээс үзэхэд Улаанбаатар хотын гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтрал шууд нөлөөлж байна.

Улсын хэмжээнд дээрх хугацаанд нийт 93.863 хүн эрүүлжүүлэгдсэний 74.3 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Шинжлэх ухаан, технологийн Их сургуулиас хийсэн Системийн динамик судалгаагаар архи, согтууруулах ундаа худалдах цэгийг 10 хувиар бууруулахад гэмт хэрэг 8.0 хувь, цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэхэд 12.0 хувиар буурах тооцоолол гарсан нь гэмт хэрэг, архидалт хоёрын харилцан шууд хамааралтай болохыг харуулж байна. Иймээс архи, согтууруулах ундаа худалдан борлуулах цэгийн тоог цөөлөх, шинээр олгох тусгай зөвшөөрөлд тавих стандарт, шаардлагыг өндөржүүлэх тухай санал боловсруулан холбогдох эрх бүхий төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 33.9 хувь нь гэр, орон сууц, 19.4 хувь нь гудамж талбай, 9.3 хувь нь олон нийтийн газар, 0.5 хувь нь нийтийн тээвэр, 1.3 хувь нь төрийн байгууллага, 0.6 хувь нь төрийн бус байгууллага, 9.2 хувь нь аж ахуйн нэгж, 4.4 хувь нь авто зам, 21.5 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байх бөгөөд гэмт хэрэгт холбогдсон этгээдийн 42.5 хувь нь 18-29 насны залуус, үүний 51.7 хувь нь ажилгүй, 18.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байгаа нь хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмж нь гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлд шууд нөлөөлж байгааг харуулж байна.

Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр Улаанбаатар хотод жилд дунджаар 41 000 хүүхэд төрж, нийслэлийн төсвийн орлого 8.0 хувиар, зарлага 9.0 хувиар, хэрэглээний үнийн индекс 1.0 хувиар тус тус өссөн байх бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дурдсанаар манай улсад Улаанбаатар хотоос гадна нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагасан 70 гаруй төв суурин газарт хүн амын тоо, төвлөрөл бий болохоор байна.

Иймээс Улаанбаатар хот болон шинээр бий болж болзошгүй засаг захиргааны нэгжийг байгуулахдаа нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, дэд бүтэц, хороодын тоо, айл өрх, хүн ам, төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөн, аж үйлдвэр, боловсрол, оршин суугчдын амьдралын чанар, орлого, нийгмийн халамж, ажил эрхлэлт, эмнэлэг, нийгмийн үйлчилгээ, оршин суугчдын амьдралын хэв маягийг онцгой анхаарч холбогдох судалгаа, шинжилгээ, эрдэмтэн судлаач нарын санал дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах шаардлагатай байна.

Орон нутгийн нөхцөл байдал:

Орон нутаг дахь цагдаагийн байгууллагуудад 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 66.947 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 18.261 буюу 27.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 48.686 буюу 72.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 543 буюу 0.8, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1759 буюу 3.7 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 1216 буюу 6.2 хувиар буурсан.

Сүүлийн 10 жилийн дунджаар орон нутагт жилд 9645, сард 803, хоногт 26 гэмт хэрэг үйлдэгдсэн судалгаа байна.

Орон нутагт өмнөх оноос хулгайлах гэмт хэрэг 33.4, мал хулгайлах 41.8, дээрэмдэх 51.5, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 7.6, хүчиндэх 26.2, залилах гэмт хэрэг 20.1 хувиар тус тус буурсан байх бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргийн 59.7 хувь буюу 10 хэрэг тутмын 4 нь хулгайлах, 2 нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг эзэлж байна.

Харин хүнийг алах гэмт хэрэг 11.5, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 26.9 хувь, хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.3 дахин, Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.7 дахин, хүний хувийн, улс төрийн эрх чөлөөний эсрэг хэрэг 4.0 дахин тус тус өсжээ.

Нийт 19 аймагт гэмт хэрэг 42.5 хүртэл хувиар буурснаас Дорноговь, Хэнтий, Өвөрхангай, Увс аймагт 33.6 болон түүнээс дээш хувиар буурсан хэдий ч орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 30.5 хувийг согтуугаар үйлдсэн байгаа нь Улаанбаатар хотоос 2.0 дахин өндөр үзүүлэлттэй гарлаа.

Ялангуяа согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг Дархан-Уул, Төв, Орхон, Дорнод аймаг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг Баянхонгор, Дархан-Уул, Төв, Хөвсгөл, галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг Ховд, Хөвсгөл аймагт тус тус өндөр, гэмт хэрэгт холбогдож байгаа иргэдийн 70.0 орчим хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй байгаа нь бүс нутгийн хөгжил, дэд бүтэц, аж үйлдвэр, амьжиргааны түвшин, ажлын байрны хүртээмж нөлөөлж байна.

Түүнчлэн дэд бүтэц, аялал жуулчлалтай холбоотойгоор Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Биндэр, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, уул уурхайтай холбоотойгоор Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, хилийн боомт, чөлөөт бүстэй холбоотойгоор Өмнөговь аймгийн Цагаанхад, Гашуунсухайтын боомт, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын, үйлдвэрлэлжилттэй холбоотойгоор Завхан аймгийн Тосонцэнгэл, Дорноговь аймгийн Алтанширээ, Улаанбаатар хотын дагуул Шинэ Зуунмод хот, газар тариалангийн хөгжилтэй холбоотойгоор Ховд аймгийн Булган, Сэлэнгэ аймгийн Мандал суманд хүн ам ихээр төвлөрөн суурьших хандлагатай байна.

Ялангуяа орон нутгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд урт хугацаандаа нөлөөлөх хүчин зүйл нь уул уурхай, ашигт малтмал дагасан ажиллах хүчний иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын төвлөрөл юм.

2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг ба коронавирусын цар тахлын харилцан нөлөөлөл:

Цар тахалтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй хууль, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэр, нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн актаас цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хамааралтай 48 зүйл заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Үүнтэй холбоотойгоор дээрх эрх зүйн актын цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль сахиулах үйл ажиллагаанд хамааралтай хэсэгт судалгаа-шинжилгээ хийж үзэхэд Цагдаагийн ерөнхий газрын нэр удирдлагад нэр зааж, үүрэг болгосон 11, цагдаагийн байгууллага, алба хаагчийн хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд хяналт тавих, хэв журам сахиулахад хамаарал бүхий зүйл, заалт 37 байна.

Монгол Улсад 2020 онд гэмт хэрэг 26.8 хувиар буурч, зөрчил 4.6 хувь буюу өмнөх жилүүдээс харьцангуй бага хувиар өссөн нь дэлхий нийтийг цочирдуулсан коронавиурсын халдварт өвчний улмаас үүссэн хөл хорио, нийгэм, эдийн засгийн нөлөөллөөс хамааралтай гэж дүгнэж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын хугацаанд цагдаагийн байгууллага нь тэргүүн шугамд ажиллаж коронавирусийн халдвар тээгч болон хавьтлыг олж тогтоох, газар, орныг бүслэн хаах, тусгаарлах байр, эмнэлгийн бүс, гудамж, зам талбайг хамгаалалтад авч, хөл хорионы дэглэмийг сахиулах, иргэд, олон нийтэд ухуулга сурталчилгаа явуулах ажил, арга хэмжээг шуурхай гүйцэтгэж байна.

Өнгөрсөн онд иргэдийн хөдөлгөөнийг тодорхой хугацаанд үе шаттай хязгаарлаж, цагдаагийн хамгаалалт, хяналтыг нэмэгдүүлсэн нь хорио цээрийн дэглэмийг сахиулахаас гадна болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөг үзүүлсэн.

Хязгаарлалт, хөл хорион тогтоосон үеэр байгууллага, бизнесийн үйл ажиллагаа хумигдан гудамж, зам талбайн хөдөлгөөн зогсож хулгайлах, залилах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, бусдын эрх чөлөө, өмчлөх эрхэд халдах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зэрэг зарим төрлийн гэмт хэрэг 10-64 хувь буурсан нь нийт гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлсөн гэж үзэхээр байна.

Харилцаа, холбооны зохицуулах газрын 2020 оны статистик мэдээгээр иргэдийн цахим хэрэглээ 2.0 дахин нэмэгдсэн байх бөгөөд үүнийг дагасан цахим хууль бус худалдаа, биеэ үнэлэлт, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдэл өссөн нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.6 дахин өсөхөд нөлөөлжээ.

Коронавирусын тархалтаас үүдэлтэй олон улсад зарим төрлийн гэмт хэргийн гаралт буурч, зарим улс оронд тодорхой төрлийн гэмт хэргүүд өсч бүртгэгдсэн. Тухайлбал, 2020 оноос хойш 130

гаруй улс оронд 4.7 тэрбум хүн 6-245 хоногийн хугацаанд хөл хорионд орсон.[1] Энэ хугацаанд цахим орчинд үйлдэгдэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хууль сахиулагчид халдах, жагсаал, цуглаан хийх зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд 30 хүртэл хувиар өссөн үзүүлэлт гарсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2020 онд хийсэн цар тахал ба хүчирхийллийн талаарх судалгаагаар өнгөрсөн онд 243 сая охид эмэгтэйчүүд гэр бүлийн орчинд бие махбодь, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Энэ төрлийн гэмт хэрэг цар тахлаас хамаарсан эрүүл мэнд болон эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 20-60 хүртэл хувиар өсөх төлөвтэй байгааг дурдсан.

Иргэд хөл хориог эсэргүүцэн эмнэлэг, цагдаагийн газрын өмнө жагсах, шинжилгээ авах цэгүүдийг шатаах, дээрэм тонуул хийх, маск зүүхээс татгалзах, тагтан дээрээсээ орилох, юм нүдэх, цагдаагийн ажилтанд халдах гэмт хэрэг, зөрчлүүд 36 улс оронд нэмэгдсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлийн цаашдын төлөв байдлын талаар:

Манай улсын хувьд хийгдсэн Системийн динамик судалгаагаар хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн суурь шалтгаан нь гэмт хэрэг жилд дунджаар 6 хувиар өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. Ялангуяа хулгайлах, залилах гэмт хэргийн гаралт жил бүр 8 хувиар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 10 хувиар, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэрэг 11 хувь, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

Коронавирусын тархалтын нөхцөл байдлаас хамаарч 2021 онд гэмт хэрэг тодорхой хувиар өсч бүртгэгдэнэ. Учир нь цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 онд гэмт хэрэг тогтмол хадгалагдаж байсан түвшингөөсөө огцом буурсан бөгөөд хөл хорионы дэглэм өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн амьдрал хэвийн байдалдаа шилжсэн тохиолдолд гэмт хэрэг гаралт эргээд өсөх буюу “U” хэлбэрийн өөрчлөлтийг авчирна.

Согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх, цагдаагийн хүн хүчийг нэмэх, шилжин суурьшилтыг хязгаарлах зэрэг зарим төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь гэмт хэргийн гаралт богино хугацаандаа буурах боловч урт хугацаандаа боловсролын байгууллагын төсвийн хувийг нэмэгдүүлж бүх шатны боловсролын хөтөлбөрийг шинэчлэх, ажлын байрыг үе шаттай нэмэгдүүлж, хот төлөвлөлт, шилжилт хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах цогц арга хэмжээг авах шаардлагатай байна. Энэ тохиолдолд бүртгэгдэж буй гэмт хэргийг 20 хүртэл хувиар бууруулах боломжтой юм.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээлэлд тулгуурлан шугаман хамаарлаар тооцон үзвэл ирэх жилүүдэд халаасны хулгай 4, 10, 12 дугаар сард, орон байрны хулгай 4, 8, 9, 10 дугаар сард, малын хулгай 9-11 дүгээр сард, хүний эрх чөлөө, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4-5 дугаар сард, хүчиндэх, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6-9 дүгээр сард, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг 8-11 дүгээр сард, амиа хорлох тохиолдол 3-7 сард тус тус нэмэгдэх хандлагатай байна.

Ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг судалж үзэхэд анхаарал, болгоомжгүй байдал, уур бухимдал, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг шалтгаанууд зонхилж байна.

Иймд иргэдэд туслах, тайлбарлах, зөвлөх, шаардлага, мэдэгдэл хүргүүлэн баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хамтарсан баг, хэсгийн ахлагч, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, малчдын нөхөрлөл зэрэг байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг баримтлах нь дээрх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд гол нөлөөг үзүүлнэ.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тогтмол өсч байгаа нь иргэдийн цахим хэрэглээтэй шууд холбоотой, нөгөө талаар цар тахлын халдварын улмаас хөл хорио тогтоосноор иргэдийн орлого буурсан, нийгмийн сэтгэл зүй тогтворгүй байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, ахуйн хүрээний архидалтын улмаас хүний амь нас эрсдэх, хохирох, амиа хорлох, бага насны хүүхдийг хүчиндэх, хайхрамж болгоомжгүйгээс золгүй байдлаар амь насаа алдах эрсдэл буурахгүй байна.

Өнөөдрийн байдлаар нийт зөрчлийн 90 орчим хувийг эзэлж байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчих үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зам тээврийн осол болон түүнд ногдуулж буй торгох шийтгэлийн үр нөлөөг корреляцын шинжилгээгээр судалж үзэхэд ирэх 10 жилд торгуулийн хэмжээ өсөхийн хирээр ослын тоо дагаад

[1] https://covid19-projections.com/

тогтмол өсөх хандлагатай байна. Системийн динамик судалгаагаар торгуулийг нэмээд зөрчил буурахгүй гэсэн тооцоолол гарсан.

Торгуулийн хэмжээг өсгөхөд зам тээврийн ослын тоо богино хугацаандаа буурах боловч урт хугацаандаа өсөх хандлагатай тул бусад төрлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Нөгөө талаар судалгаагаар торгох шийтгэлийн биелэлт хангалтгүй байгаа бөгөөд сүүлийн 5 жилд бэлэн бус хэлбэрээр оногдуулсан торгуулийг 10-аас дээш удаа төлөөгүй 19990, 20-оос дээш удаа төлөөгүй 4108, 50-аас дээш удаа төлөөгүй 296, 100-аас дээш удаа төлөөгүй 29 жолооч замын хөдөлгөөнд оролцож байна.

Иймд жолооч үүргээ биелүүлээгүй, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй, осол, зөрчилд удаа дараа холбогдсон, ногдуулсан торгуулийг хугацаандаа төлөөгүй бол ангилал ахиулах, такси, нийтийн тээврийн хэрэгсэл жолоодох, хот хооронд тээвэр хийх, жолооны үнэмлэх авах эрхийг хязгаарлах зэргээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай зүй ёсоор тулгарч байна.

ЗӨВЛӨМЖ:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд:

Засгийн газраас хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын яамны дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд иргэдийн амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд арга хэмжээг тусгахдаа суурь болон хавсарга судалгааны үр дүнг удирдлага болгох;

Хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, тээвэр логистик, хүн амын төвлөрөл суурьшлын төлөвлөгөө, хүн ам, боловсрол, нийгмийн үйлчилгээ, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах бодлогыг цогцоор нь шийдвэрлэх, аль нэг салбарт хийгдэх өөрчлөлт шинэчлэлтийг бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

Монгол орны газар зүйн программ хангамж, иргэний бүртгэлийн ухаалаг систем зэрэг улсын хэмжээний платформуудыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд ашиглах, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй, халдлагад өртөхгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байх.

Нутаг дэвсгэрийн удирдлагын түвшинд:

Улаанбаатар хот, аймгууд нь шилжин ирэгсэд, оршин суугчдад тавих хяналтыг чангатган, зөвшөөрөлгүй шилжин суурьшигчдын тоог хязгаарлах бодлого баримтлах, шаардлагатай тохиолдолд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

Хүн амын тоо, нягтаршил, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарсан төрийн үйлчилгээний шинэ стандарт буюу оршин суугаа газрын 2-5 км тойрогт нийгмийн суурь үйлчилгээг бүрэн авах боломжтой олон улсын стандарт, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх;

Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хандлага, сэтгэлгээг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг иргэддээ хүртээмжтэй хүргэх, сум, дүүрэг, баг хороонд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдүүлэх, сонирхлоороо нэгдсэн идэвхтэй бүлэг, хамтлаг байгуулах гэх мэт шинэлэг арга хэлбэрийг бий болгох.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад:

Гэмт хэрэгтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх уламжлалт арга барилыг өөрчилж, өнөө цагийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон нийтэд түшиглэсэн, мэдээлэлд суурилсан цагдан сэргийлэх үйл ажиллагаа явуулж, цагдаагийн байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх;

Гэмт хэрэг, зөрчлийн газарт очиж аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ хийж дахин гэмт хэрэг, зөрчил гаргуулахгүй байх талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, сануулга өгч баталгаа авах, дутагдлыг газар дээр нь засуулах;

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай мөрдөгчийн мэдэгдэл, түүний үр дүнг нэгжүүдийн криминологи судалгааны багийн хурлаар хэлэлцүүлэх, биелэлт хангалтгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад бусад байгууллагатай хамтарсан шалгалт хийх, албан шаардлага, мэдэгдлийг дахин хүргүүлж биелэлтийг нь тооцох;

Үйлдэгдсэн ноцтой гэмт хэргийн талаар ажлын хэсэг гарган судалгаа хийж, шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар криминологи судалгааны багийн хурлаар хэлэлцэн, чиглэл хариуцсан ажилтнуудад хугацаатай үүрэг өгөх, үр дүнг тооцох;

Иргэдтэй харилцаж буй цагдаагийн алба хаагчдад хууль тогтоомжид заасан хариуцлага, эрх, үүргийг урьдчилан тайлбарлах, зөвлөх чиглэлээр идэвх санаачлагтай ажиллахыг даалгах. Тухайлбал, ахуйн аюулгүй байдлыг хангах, гал түймрийн аюулаас сэргийлэх, орон гэрээ эзэнгүй орхих, бага насны хүүхдийг хараа хяналтгүй байлгасны улмаас үүсэж болох эрсдэлээс сэргийлэх ухуулга сурталчилгааг хороо, баг хариуцсан ажилтнуудтай хамтран иргэдийн дунд зохион явуулах;

Хариуцсан нутаг дэвсгэртээ тусгай халамж, анхаарал шаардлагатай эмзэг болон зорилтот бүлгийн хүмүүсийн оршин суух хаягаар нь явж урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааг хийж энэ талаар тэмдэглэл үйлдэх, боломжтой бүх тохиолдолд бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ажил хариуцсан ажилтан, алба хаагчдаас дэмжлэг, туслалцаа хүсэж энэ талаараа баримт бүрдүүлэх;

Архаг архичин, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай эсвэл тийм төрлийн хэрэгт холбогдож, хяналтад байдаг хүмүүстэй уулзаж, хаяг, байршлыг нь тогтоож эрүүл мэндийн байгууллагатай хамтран бие болон эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгч, уулзсан тухай тэмдэглэл үйлдэх;

Айл өрхүүдэд хадгалагдаж буй галт зэвсгийн аюулгүй байдлын талаар хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг газар дээр нь шийдвэрлэж зөвлөгөө, зааварчилга өгч, энэ талаараа тэмдэглэл үйлдэх;

Гэмт хэрэгтэй тэмцэх алба, нэгжийн мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааны түвшин, сорилт бэрхшээлүүдийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөх.

Цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбогдуулан засгийн газар, онцгой комисс, ажлын хэсгийн түвшинд цаашид авах арга хэмжээ:

Бүх нийтийн бэлэн байдлын хугацаанд эрх бүхий байгууллагаас гаргаж буй нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын биелэлтийг тооцох, давхардал, хийдлийг арилгах, үүнтэй холбоотойгоор өмнө нь үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;

Баталсан хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, шат шатны төрийн байгууллагын уялдаа холбоо, эрх үүргийг тодорхой болгох, биелэлт үр дүнг тооцох аргачлалыг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог бий болгох.

Онцгой нөхцөл байдлын үед тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын хүн хүч хязгаарлагдмал нөөцтэй гэдгийг анхаарч, орчин үеийн техник, технологийн шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

Онцгой нөхцөл, хорио цээр, цар тахалтай холбоотой гарч байгаа нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын иргэдэд цаг алдалгүй шуурхай, үнэн зөв, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, ойлгуулан таниулах.

---oooOooo---

ХОЁР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага нь 2020 онд хүн, хуулийн этгээдээс 260.357 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 67.547 буюу 25.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 192.810 буюу 74.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 1178 буюу 0.5, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 7790 буюу 4.2 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 6612 буюу 8.9 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 25721 буюу 38.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 38867 буюу 57.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 599 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 104.996 буюу 54.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 85.853 буюу 44.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 947 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 23064 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 14633 буюу 63.4 хувь нь Улаанбаатар хотод, 8420 буюу 36.5 хувь нь орон нутагт, 11 буюу 0.1 хувь нь бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 8460 хэрэг буюу 26.8 хувиар, нийслэлийн хэмжээнд 5628 хэрэг буюу 27.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 2784 хэрэг буюу 24.8 хувиар, бусад газар /хилийн чанадад/-т 48 хэрэг буюу 81.4 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 10 жилээр:



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 27195, сард 2266, хоногт 75, цагт 3 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.



Гэмт хэрэг 19 аймаг, 7 дүүрэгт 3.9 хувиас 42.5 хувиар буурч, 2 аймаг, 2 дүүрэгт 0.7 хувиас 85.7 хувиар өссөн байна.

Д/д	Нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт		Д/д	Нэгж	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Too	Хувь					Too	Хувь
1	Архангай	568	435	-133	-23.4	17	Төв	865	737	-128	-14.8
2	Баян-Өлгий	306	308	2	0.7	18	Увс	327	188	-139	-42.5
3	Баянхонгор	642	462	-180	-28.0	19	Ховд	481	394	-87	-18.1
4	Булган	459	349	-110	-24.0	20	Хөвсгөл	743	535	-208	-28.0
5	Говь-Алтай	235	151	-84	-35.7	21	Хэнтий	841	531	-310	-36.9
6	Говьсүмбэр	154	148	-6	-3.9			**Нийслэлд**			
7	Дархан-Уул	803	566	-237	-29.5	22	Баянгол	2834	2257	-577	-20.4
8	Дорноговь	550	318	-232	-42.2	23	Баянзүрх	5465	4083	-1382	-25.3
9	Дорнод	605	476	-129	-21.3	24	Сүхбаатар	3283	2023	-1260	-38.4
10	Дундговь	211	196	-15	-7.1	25	Сонгинохайрхан	3470	2337	-1133	-32.7
11	Завхан	247	271	24	9.7	26	Хан-Уул	2055	1650	-405	-19.7
12	Орхон	747	533	-214	-28.6	27	Чингэлтэй	2642	1775	-867	-32.8
13	Өвөрхангай	613	407	-206	-33.6	28	Багануур	167	143	-24	-14.4
14	Өмнөговь	515	458	-57	-11.1	29	Багахангай	14	26	12	85.7
15	Сүхбаатар	525	408	-117	-22.3	30	Налайх	331	339	8	2.4
16	Сэлэнгэ	767	549	-218	-28.4	31	Бусад	59	11	-48	-81.4

1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 19247 буюу 83.5 хувь нь хөнгөн, 3817 буюу 16.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.5 хувиар, хүнд гэмт хэрэг 40.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.[2]



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	636	382	-39.9	1.7
	Үүнээс: Хүнийг алах	197	192	-2.5	0.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8265	7405	-10.4	32.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	207	111	-46.4	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	610	505	-17.2	2.2
	Үүнээс: Хүчиндэх	481	401	-16.6	1.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	115	189	64.3	0.9
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	39	22	-43.6	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	31	17	-45.2	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	18341	12061	-34.2	52.3
	Үүнээс: Хулгайлах	8968	5100	-43.1	22.1
	Залилах	4688	404	-53.5	1.8
	Дээрэмдэх	868	4270	-8.9	18.5
	Мал хулгайлах	1809	1041	-42.5	4.5
9	Эдийн засгийн гэмт хэрэг	247	123	-50.2	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	29	1	-96.6	0

[2] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	333	291	-12.6	1.3
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	172	80	-53.5	0.3
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	523	8	-98.5	0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	341	211	-38.1	0.9
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг	489	622	27.2	2.7
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	5	5	0	0
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	57	146	2.6 дах	0.6
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1276	985	-22.8	4.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1263	981	-22.3	4.3
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	12	6	-50	0
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	0	0	0	0

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 3470 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 3519 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 3383 буюу 14.7 хувь нь лхагва гарагт, 3291 буюу 14.3 хувь нь пүрэв гарагт, 3408 буюу 14.8 хувь нь баасан гарагт, 2997 буюу 13.0 хувь нь бямба гарагт, 2996 буюу 13.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 5838 буюу 25.3 хувь нь 06:00-14:00 цагт, 6621 буюу 28.7 хувь нь 14:00-19:00 цагт, 3410 буюу 14.8 хувь нь 19:00-22:00 цагт, 7195 буюу 31.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 7817 буюу 33.9 хувь нь гэр орон сууцанд, 4464 буюу 19.4 хувь нь гудамж талбайд, 2145 буюу 9.3 хувь нь олон нийтийн газарт, 115 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 289 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 149 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 2115 буюу 9.2 хувь нь аж ахуйн нэгжид, 1005 буюу 4.4 хувь нь авто замд, 4965 буюу 21.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 4855 буюу 21.1 хувь нь согтуугаар, 3352 буюу 14.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1482 буюу 6.4 хувь нь бүлэглэн, 811 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 1138 буюу 4.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас тус тус үйлдэгдсэн байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хэргийн 9405 буюу 40.8 хувь нь далд аргаар үйлдэгдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 51.9 хувь, нийслэлд 48.3 хувь, орон нутагт 59.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс улсын хэмжээнд 7.0, нийслэлд 9.4, орон нутагт 2.3 нэгжээр тус тус өссөн байна.

2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 17666 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11750 хэрэг буюу 39.9 хувиар, үүнээс 9161 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4049 буюу 30.7 хувиар тус тус буурчээ.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 16667 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 443 буюу 2.6 хувиар буурсан. Холбогдогчдын 13760 буюу 82.6 хувийг эрэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар, 990 буюу 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 27.0 хувиар тус тус буурч, 2907 буюу 17.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 27.1 хувиар өссөн байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Гадаадын 21 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 33 буюу 61.1 хувиар буурсан байна.

Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 23050 иргэн, 66 хуулийн этгээд хохирч, үүнээс 670 хүн нас барж, 8175 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 7732 буюу 25.1 хувиар, нас барсан хүн 260 буюу 28.0 хувиар, гэмтсэн хүн 552 буюу 6.3 хувиар тус тус буурсан.



4.2.Учирсан хохирол.



Хүн, хуулийн этгээдэд учирсан 254937.3 сая төгрөгийн хохирлын 82079.4 сая төгрөг буюу 32.2 хувийг нөхөн төлүүлж, 6421.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 92590.7 сая буюу 57 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 38319.8 сая буюу 87.6 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 584.3 сая
буюу 8.3 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил

5.1 Нийт бүртгэгдсэн зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 2.276.868 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 101.043 буюу 4.6 хувиар, 2.272.346 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 104.011 буюу 4.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 2.058.347 буюу 90.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 91212 буюу 4.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 10.306 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 5311 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 111.692 буюу 4.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 2.148.231 хүн, 85.633 хуулийн этгээдийг 66.0 тэрбум төгрөгөөр торгох, 16.891 хүнийг баривчлуулах, 21.591 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 24701 буюу 1.2 хувиар, хуулийн этгээдийг торгосон шийтгэл 84.639 буюу 86.1 дахин, баривчилсан шийтгэл 1595 буюу 10.4 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 6924 буюу 24.3 хувиар буурсан байна.

5.2 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа.

Улсын хэмжээнд 2020 онд нийт 93.863 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.213 буюу 15.5 хувиар буурчээ. Эрүүлжүүлэгдсэн хүний 69.726 буюу 74.3 хувь нь Улаанбаатар хотод, 24.137 буюу 25.7 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 85.149 буюу 90.7 хувь нь эрэгтэй, 8.714 буюу 9.3 хувь нь эмэгтэй, 218 буюу 0.2 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Архины албадан эмчилгээнд 509 хүн, сайн дурын эмчилгээнд 539 хүнийг хамруулсан байна.

---oooOooo---

ГУРАВ. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн хэмжээнд 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 159.940 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 46.334 буюу 29.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 113.606 буюу 71.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 8981 буюу 5.3, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 4766 буюу 9.3, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 4215 буюу 3.6 хувиар тус тус буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 14.818 буюу 32.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 29.621 буюу 63.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 340 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 41.831 буюу 36.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 71.061 буюу 62.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 152 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 100 буюу 0.1 хувийг ердийн журмаар тус тус шийдвэрлэсэн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 14.633 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5628 буюу 27.8 хувиар буурч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 63.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 17.458, сард 1454, хоногт 49 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 10 жилээр:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Д/д	Дүүрэг	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянгол	2834	2257	-577	-20.4
2	Баянзүрх	5465	4083	-1382	-25.3
3	Сүхбаатар	3283	2023	-1260	-38.4
4	Сонгинохайрхан	3470	2337	-1133	-32.6
5	Хан-Уул	2055	1650	-405	-19.7
6	Чингэлтэй	2642	1775	-867	-32.8
7	Багануур	167	143	-24	-14.4
8	Багахангай	14	26	12	85.7
9	Налайх	331	339	8	2.4



1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 12.572 буюу 85.9 хувь нь хөнгөн, 2061 буюу 14.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 23.1 хувиар, хүнд гэмт хэрэг 47.3 хувиар тус тус буурсан байна.

1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2020 он.[3]



1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2019 он	2020 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	378	208	-44.9	1.4
	Үүнээс: Хүнийг алах	110	95	-13.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5183	4564	-11.9	31.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	130	65	-50.0	0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	249	255	2.4	1.7
	Үүнээс: Хүчиндэх	214	203	-5.1	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	89	130	46.1	0.9
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	1	50.0	
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	28	16	-42.9	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	26	13	-50.0	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	12626	8355	-33.8	57.1
	Үүнээс: Хулгайлах	6537	3481	-46.7	23.8
	Дээрэмдэх	738	341	-53.8	2.3
	Залилах	3859	3621	-6.2	24.7
	Мал хулгайлах	128	63	-50.8	0.4
9	Эдийн засгийн гэмт хэрэг	130	70	-46.2	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	242	237	-2.1	1.6
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	94	50	-46.8	0.3
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	299	4	-98.7	0.1
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	229	124	-45.9	0.8
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг	40	52	30.0	0.4
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.0
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	47	119	2.5 дах	0.8
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	595	431	-27.6	2.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	588	430	-26.9	2.9
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	0.1

1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 2241 буюу 15.3 хувь нь даваа гарагт, 2204 буюу 15.1 хувь нь мягмар гарагт, 2068 буюу 14.1 хувь нь лхагва гарагт, 2108 буюу 14.4 хувь нь пүрэв гарагт, 2225 буюу 15.2 хувь нь баасан гарагт, 1907 буюу 13.0 хувь нь бямба гарагт, 1880 буюу 12.9 хувь нь ням гарагт

[3] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 4073 буюу 27.8 хувь нь 06:00-14:00 цагт, 4239 буюу 29.0 хувь нь 14:00-19:00 цагт, 2039 буюу 13.9 хувь нь 19:00-22:00 цагт, 4282 буюу 29.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл нийт гэмт хэргийн 4965 буюу 33.9 хувь нь гэр орон сууцанд, 3508 буюу 24.0 хувь нь гудамж талбайд, 1768 буюу 12.1 хувь нь олон нийтийн газарт, 93 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 136 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 111 буюу 0.8 хувь нь төрийн бус байгууллагад, 1786 буюу 12.2 хувь нь аж ахуйн нэгжид, 446 буюу 3.0 хувь нь авто замд, 1820 буюу 12.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



Гэр, орон сууц 33.9% | Гудамж, талбай 24.0% | Олон нийтийн газар 12.1% | Аж ахуйн нэгж 12.2% | Авто зам 3.0% | Бусад газар 14.8%

1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2284 буюу 15.6 хувь нь согтуугаар, 2557 буюу 17.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 680 буюу 4.6 хувь нь бүлэглэн, 558 буюу 3.8 хувь нь хүүхэд оролцож, 584 буюу 4.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Дүүрэг	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баянгол	226	79	481	72	166	1
2	Баянзүрх	909	172	893	212	178	2
3	Сүхбаатар	155	68	307	42	89	1
4	Сонгинохайрхан	321	110	289	116	65	
5	Хан-Уул	213	65	201	47	82	2
6	Чингэлтэй	261	44	318	68	76	
7	Багануур	63	8	24	8	10	
8	Багахангай	14			3	1	1
9	Налайх	122	12	44	16	13	
	Нийт	**2284**	**558**	**2557**	**584**	**680**	**7**

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 5795 буюу 39.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 48.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.4 нэгжээр өссөн.

Улсын гэмт хэргийн илрүүлэлттэй харьцуулахад 3.6 нэгжээр бага байна.



2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 11878 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7634 хэрэг буюу 39.1 хувиар, үүнээс 5733 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1858 буюу 24.5 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 9388 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар өссөн. Холбогдогчдын 2164 буюу 23.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 48.6 хувиар өсч, 7224 буюу 76.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 6.7 хувиар, 654 буюу 7.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 16.9 хувиар тус тус буурсан байна.

3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

4.1 Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 14464 иргэн, 21 хуулийн этгээд хохирч, үүнээс 284 хүн нас барж, 4758 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 5172 буюу 26.3, нас барсан хүн 153 буюу 35.0, гэмтсэн хүн 278 буюу 5.5 хувиар, хохирсон хуулийн этгээд 5 буюу 19.2 хувиар тус тус буурсан байна.



4.2 Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 222257.5 сая төгрөгийн хохирлын 30.2 хувийг нөхөн төлүүлж, 2937.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 100548.2 сая буюу 82.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 43414.8 буюу 2.8 дахин, битүүмжилсэн хөрөнгө 404.5 сая буюу 16.0 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил

Нийслэлийн хэмжээнд нийт 198.389 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 30.117 буюу 17.9 хувиар, 196.449 зөрчлийг шийдвэрлэсэн нь 32.880 буюу 20.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 69.687 буюу 35.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 72.878 буюу 36.7 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 7257 буюу 3.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 5104 буюу 2.6 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 43.463 буюу 21.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 187.449 иргэн, 762 хуулийн этгээдийг 81748.9 мянган төгрөгөөр торгох, 7254 хүнийг баривчилах, 984 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 20.0 хувиар, баривчилсан шийтгэл 1674 буюу 30.0 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1 буюу 0.1 хувиар буурсан байна.

2020 онд Нийслэлийн хэмжээнд нийт 46.516 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4808 буюу 9.4 хувиар буурсан байна.

---oooOooo---

3.1 БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар нь 2020 онд иргэн, хуулийн этгээдээс 25003 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8848 буюу 35.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 16155 буюу 64.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 4657 буюу 15.7, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 2259 буюу 20.3, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 2398 буюу 12.9 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 2007 буюу 22.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6553 буюу 74.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 82 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 7309 буюу 45.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 8774 буюу 54.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 22 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 2257 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 577 буюу 20.4 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2856, сард 238, хоногт 9 хэрэг үйлдэгдсэн байна.

Тус дүүрэгт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.



Д/д	Хороо	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Too	Хувь
1	1-р хороо	162	117	-45	-27.7
2	2-р хороо	177	180	3	1.7
3	3-р хороо	166	144	-22	-13.2
4	4-р хороо	155	123	-32	-20.6
